



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 512

Улаанбаатар хот

**Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг  
нээлттэй сонгон шалгаруулах  
түр журам батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг нээлттэй сонгон шалгаруулах түр журмыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, зохих арга хэмжээ авч хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн  
512 дугаар тогтоолын хавсралт



## ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫГ НЭЭЛТТЭЙ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТҮР ЖУРАМ

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан тушаалд нэр дэвшигчийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү түр журмыг *Цаашид журам гэх* дагаж мөрдөнө.

1.2. Үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан, үйлдвэрийн газрын зорилго, зорилт, чиг үүргийг мэргэжил, мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай удирдах ажилтныг сонгон шалгаруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.3. Үйлдвэрийн газрын захирлын ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмыг баримтална.

1.4. Үйлдвэрийн газрын захирлын ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалт явуулахдаа хууль дээдлэх, ил тод, хараат бус байх, ашиг сонирхлоос ангид байх, шударга, эрх тэгш байх, нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

### Хоёр: Сонгон шалгаруулалт

2.1. Үйлдвэрийн газрын захирлын ажлын байрны нээлттэй сонгон шалгаруулалтыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр томилогдсон ажлын хэсэг зохион байгуулна.

2.2. Үйлдвэрийн газрын захирлыг сонгон шалгаруулах ажлын хэсэг нь салбарын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллөөс бүрдсэн 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ашиг сонирхлын зөрчилгүй, тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай хүнийг оруулна.

2.4. Ажлын хэсэг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:  
2.4.1. сонгон шалгаруулалтын тов, үргэлжлэх хугацааг тогтоох;  
2.4.2. сонгон шалгаруулалтын зарыг бэлтгэх, олон нийтэд хүргэх;  
2.4.3. сонгон шалгаруулалтад ирүүлсэн баримт бичгийг бүртгэл үйлдэн хүлээн авах;

2.4.4. сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн баримт бичгийг хянах, шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцогчоос нэмэлт баримт шаардах, холбогдох байгууллагаас лавлагаа гаргуулах;

2.4.5. сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах.

2.4.6. тухайн үйлдвэрийн газрын захирлын албан тушаалын тодорхойлолтын дагуу нэр дэвшигчид тавигдах тусгай шаардлагыг үйлдвэрийн газрын онцлог, ажлын цар хүрээ зэрэг нөхцөл байдлыг харгалзан шинэчлэн тогтоож болно.

2.5. Ажлын хэсгийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга бүр саналын эрхтэй байна.

2.6. Ажлын хэсэг сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг хурлаараа хэлэлцэн олонхын саналаар шийдвэрлэж, тэмдэглэл үйлдэнэ.

2.7. Сонгон шалгаруулах үйл ажиллагааг зөвхөн танхимаар зохион байгуулна.

### **Гурав. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх**

3.1. Ажлын хэсэг энэ журмын 2.5.1-д заасан хугацаанд сонгон шалгаруулалт явуулах бөгөөд сонгон шалгаруулалтын зарыг хуанлийн 7-оос доошгүй хоногийн өмнө тухайн хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудас болон 1-ээс доошгүй олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүртээмжтэй байдлаар олон нийтэд мэдээлнэ. Уг сонгон шалгаруулалтын зарыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын цахим хуудсанд заавал байрлуулна.

3.2. Сонгон шалгаруулалтын зард дараах зүйлийг тусгана:

3.2.1. сонгон шалгаруулалт явуулах огноо, үргэлжлэх хугацаа, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, түүнийг хүлээн авах газар, бүртгэх хугацаа;

3.2.2. ажлын байрны нэр, тавигдах ерөнхий болон тусгай шаардлага;

3.2.3. сонгон шалгаруулалтын үе шат;

3.2.4. сонгон шалгаруулах ажлын хэсгийн хаяг, харилцах утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэл явагдах хугацааг заана.

3.3. Ажлын хэсэг сонгон шалгаруулалт явуулах байр, хугацааг жич зарлана. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд ажлын хэсэг тухай бүр мэдээлнэ.

### **Дөрөв. Сонгон шалгаруулалтад оролцогчдыг бүртгэх**

4.1. Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад орохыг хүссэн иргэдээс дор дурдсан баримт бичгийг тогтоосон хугацаанд хүлээн авч бүртгэнэ:

4.1.1. төрийн албан хаагчийн анкет;

4.1.2. боловсролын түвшнийг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулга болон бусад сургалт, семинарт хамрагдсан гэрчилгээ, сертификатын хуулбар;

4.1.3. иргэний үнэмлэх;

4.1.4. ажил байдлын тодорхойлолт (өөрийн хийж гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл);

4.1.5. нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /e-mongolia-с татан авах/;

4.1.6. иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-с татан авах/;

4.1.7. тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг ур, чадвараа илэрхийлсэн өргөдөл;

4.1.8. нэр дэвшигчийн зүгээс эссэ бичиж ирүүлэх. Үүнд:

4.1.8.1. үйлдвэрийн газрын захирлын үүрэгт ажилд томилогдсоноор салбарт гарах ахиц дэвшил болон байгууллагыг урт, дунд хугацаанд хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилго, зорилтыг тодорхой тусгасан байна.

4.1.8.2. “Эссэ”-г бичихдээ нээлттэй эх үүсвэрээс хийсэн судалгаанд түшиглэн, статистик тоо баримт дурдан хүрэх үр дүнг тодорхойлсон байна.

4.1.8.3. “Эссэ” нь нийт 2,500-3,000 үгтэй байна.

4.1.8.4. “Эссэ” нь сонгон шалгаруулалтад нэр дэвшигчийн бүрдүүлэх материалын бүрдэлд багтсан байх тул заавал бичиж ирүүлнэ.

4.2. Бусад;

4.3. Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй болон энэ журмын 4.1-д заасан баримт бичгийг дутуу бүрдүүлж ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасах, дараагийн шатны сонгон шалгаруулалтад оруулахгүй байх үндэслэл болно.

### **Тав. Сонгон шалгаруулалтын үе шат**

5.1. Сонгон шалгаруулалт дараах үе шаттай байна.

5.1.1. баримт бичгийн бүрдэл;

5.1.2. сорилын шалгалт;

5.1.3. ярилцлага;

5.1.4. сонгон шалгаруулалтын дүнг гаргах;

### **Зургаа. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах**

6.1. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцохоор материалаа ирүүлсэн нэр дэвшигчдийн материалыг хянан үзэж, бичиг баримтын бүрдэл, үйлдвэрийн газрын захирлын албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргана.

6.2. Ажлын хэсгийн санал дүгнэлтээр шалгарч 2 дугаар үе шатанд тэнцсэн нэр дэвшигчдээс сорилын шалгалт авна. /тухайн шалгалт нь оролцогчийн мэдлэгийн түвшин, асуудлыг шийдвэрлэх чадварыг тогтооход чиглэнэ/.

6.2.1. ерөнхий мэдлэг (хууль, эрх зүй болон бусад мэдлэг);

6.2.2. дүн шинжилгээ хийх чадвар (сэтгэхүйн чадамж болон бусад ур чадвар).

6.3. Сорилын шалгалтаар нийт авбал зохих онооны 70 ба түүнээс дээш хувиар үнэлэгдсэн тохиолдолд дараагийн шатанд тэнцэнэ.

6.4. Ярилцлагын шалгалт нь оролцогчийн тухайн үйлдвэрийн газрын урт, дунд хугацаанд хөгжүүлэх төлөвлөгөө, зорилго зорилтын талаарх эссэ, танилцуулга илтгэлтэй танилцан, ярилцлага хийж үнэлгээ өгөх байдлаар явагдана.

6.5. Сонгон шалгаруулалтын үнэлгээг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

6.5.1. баримт бичгийн бүрдэл, нэр дэвшигчид тавигдах ерөнхий болон тусгай шаардлага- 30 оноо

6.5.2. Сорилын шалгалт- 40 оноо

### 6.5.3. Ярилцлага -30 оноо

6.6. Ажлын хэсгийн гишүүн оролцогчдын талаар санал, дүгнэлт гаргах болон үнэлгээ өгөхдөө Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэхээр байвал энэ талаар мэдэгдэж санал, дүгнэлт гаргах үнэлгээ өгөхөд оролцохгүй.

6.7. Сонгон шалгаруулалтын тестийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс боловсруулан баталгаажуулсан байна.

6.8. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж дууссан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан дүгнэлт гаргана. Уг дүгнэлтэд хурлын тэмдэглэл болон сонгон шалгаруулалттай холбоотой бүх бичиг, баримтуудыг хавсаргасан байна.

### **Долоо.Нэр дэвшүүлэх**

7.1. Үйлдвэрийн газрын захирлын албан тушаалд сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдээс тухайн албан тушаалын шаардлагыг хангаж, сонгон шалгаруулалтын үнэлгээгээр хамгийн өндөр оноо авсан нэг иргэний нэрийг дэвшүүлж, дүгнэлтийн хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулах газрын даргад танилцуулан Газрын хуралд томилох тухай санал гаргах.

7.2. Үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтад оролцсон этгээдэд өөртэй нь холбоотой сонгон шалгаруулалтын процесс, холбогдох мэдээлэл шийдвэрүүдийг танилцуулж болно.

7.3. Үйлдвэрийн газрын захирлын сонгон шалгаруулалтыг үр дүн, холбогдох баримт бичгийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд нийтэд мэдээлэх.

7.4. Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг удирдах албан тушаалд томилохгүй.

### **Найм.Бусад зүйл**

8.1. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд аливаа эрх бүхий дээд байгууллага, төрийн өндөр албан тушаалтны зүгээс нөлөө үзүүлэхийг хориглоно.

8.2. Сонгон шалгаруулалттай холбогдсон асуудлаар гаргасан маргааныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

.....о0о.....